МЭДЭЭ · 2024 оны 12-р сарын 10

ПРОКУРОРУУД БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ АРДЫН ПРОКУРОРЫН ГАЗАРТ ТУРШЛАГА СУДЛАХ АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА



Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын прокурорууд БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын прокурорын газарт туршлага судлах ажлын айлчлал хийж байна.



Хар тамхи, мансууруулах бодис, хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр туршлага судлах зорилго бүхий тус айлчлалын хүрээнд БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Ардын прокурорын газар болон Эрээн, Хөх хот, Эжэнхороо, Ордос хотын прокурорын газрын үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл солилцох уулзалтуудыг зохион байгуулах юм.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1030